



**ГАЗАР ШИМ ҮЙЛДВЭР ХК-Н ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ  
ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ**

№001/002/20250408-001

2025 оны 04 дүгээр сарын 08-ны өдөр

Улаанбаатар хот

Компанийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн  
талаар дүгнэлт гаргах тухай

Компанийн тухай хуулийн 76.1 дэх заалт, 96.1 дэх заалт, Газар шим үйлдвэр ХК-ийн  
дүрмийн 7.31.5 дахь заалтад тус тус үндэслэн ТОГТООХ НЬ:

1. Компанийн 2024 оны үйл ажиллагааны нийт орлогыг 42,600,897,007 (дөчин хоёр тэрбум зургаан зуун сая найман зуун ерөн долоон мянга долоон) төгрөг, нийт зардлыг 35,041,934,679 (гучин таван тэрбум дөчин нэгэн сая есөн зуун гучин дөрвөн мянга зургаан зуун далан ес) төгрөг, цэвэр ашгийг 7,558,962,327 (долоон тэрбум таван зуун тавин найман сая есөн зуун жаран хоёр мянга гурван зуун хорин долоон) төгрөгөөр тус тус баталсугай.
2. Газар шим үйлдвэр ХК-ийн 2024 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайланг хангалттай гэж дүгнэсүгэй.
3. Газар шим үйлдвэр ХК-ийн 2025 оны үйл ажиллагааны тайлангийн дүгнэлтийг нэгдүгээр хавсралтаар, санхүүгийн тайлангийн дүгнэлтийг хоёрдугаар хавсралтаар баталсугай.
4. Газар шим үйлдвэр ХК-ийн 2024 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх Төлөөлөн удирдах зөвлөлөөс гаргасан дүгнэлтийг Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар хэлэлцүүлж батлуулахыг Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга (Ш.Алтанбагана), Гүйцэтгэх захирал (Ц.Ганбат) нарт тус тус даалгасугай.

ТУЗ-ИЙН ДАРГА



Ш.АЛТАНБАГАНА



“Газар шим үйлдвэр” ХК-ийн Төлөөлөн удирдах  
Зөвлөлийн 2025 оны 04 дүгээр сарын 08-ны өдрийн  
001/002/20250408-001 тоот тогтоолын 01 дүгээр  
хавсралт

“Газар шим үйлдвэр” ХК-ийн 2024 оны үйл ажиллагааны тайланд өгсөн дүгнэлт

“Газар шим үйлдвэр ХК” нь олон нийтээс татан төвлөрүүлсэн хөрөнгийг зориулалтын дагуу зарцуулж, бүтээгдэхүүн үйлчилгээг нэмэгдүүлэх, шинэ тоног төхөөрөмж, зоорины барилгын гүйцэтгэлд онцгой хичээл зүтгэл гарган үнэт цаасны танилцуулгад тусгасан хөрөнгө оруулалтын төслүүдийг 90 гаруй хувийн гүйцэтгэлтэй ажилласан байна.

Удирдлагын зүгээс төлөвлөгөөт зорилтуудаа амжилттай хэрэгжүүлэхийн төлөө үйлдвэрлэлийн бүтээмжийг дээшлүүлэх, борлуулалтын үйл ажиллагаа, хүчин чадлыг нэмэгдүүлэх, бүтээгдэхүүн болон компанийн үнэ цэнийг нэмэгдүүлэхээр онцгойлон анхаарахаас гадна ре-брендингийн төслийг амжилттай хэрэгжүүлээд байна.

Компанийн ТУЗ-ийн 2025 оны 02 дугаар сарын 15-ний өдрийн №002/007/20250215-002 тоот тогтоолоор Компанийн нэгж хувьцаанд 2,60 төгрөгийн ногдол ашиг олгохоор тооцон хувьцаа эзэмшигч иргэдэд 3,115,094,338 төгрөгийн ногдол ашиг олгохоор шийдвэрлэж, цэвэр ашгийн 30-аас доошгүй хувийг ногдол ашгаар тараах амлалтаа амжилттай биелүүллээ.

Мөн шинэ бүтээгдэхүүний судалгаа болон туршилт үйлдвэрлэл, шошго зэрэг ажлуудыг амжилттай гүйцэтгэж эхний бүтээгдэхүүнүүдийг зах зээлд амжилттай нэвтрүүлээд байгаа нь 2025 оны бизнес төлөвлөгөөг хэрэгжүүлж, борлуулалт, цэвэр ашгийн хэмжээг нэмэгдүүлэхэд дэмжлэг болохоор байна.

Эдгээр үзүүлэлтүүдэд үндэслэн “Газар шим үйлдвэр” ХК-ийн 2024 оны үйл ажиллагааны үр дүнг “Хангалттай” гэж дүгнэв.



“Газар шим үйлдвэр” ХК-ийн Төлөөлөн удирдах  
зөвлөлийн 2025 оны 04 дүгээр сарын 08-ны өдрийн  
001/002/20250408-001 тоот тогтоолын 02 дугаар  
хавсралт

“Газар шим үйлдвэр” ХК-ийн 2024 оны санхүүгийн тайланд өгсөн дүгнэлт

Компанийн борлуулалтын орлого нь 2023 онд 34,312,209,541 төгрөг байсан бөгөөд өмнөх оноос 19.70 хувиар буюу 6,759,680,646 төгрөгөөр өсч 2024 онд 41,071,890,187 төгрөг, цэвэр ашгийн хэмжээ 15.64 хувиар буюу 1,022,420,221 төгрөгөөр тус тус өсч 7,558,962,327 төгрөгт тус тус хүрсэн.

Тайлант хугацаанд компанийн нийт зардлын 68.68 хувийг борлуулсан бүтээгдэхүүний өртөг, 4.17 хувийг орлогын татварын зардал, 15.06 хувийг борлуулалт, маркетингийн зардал, 8.52 хувийг ерөнхий ба удирдлагын зардал эзэлж байна.

Компанийн нийт өр төлбөр 2023 онд 11,594,297,396 төгрөг байснаас 2024 онд 8,745,675,513 төгрөг ба өмнөх оноос (2,848,621,882) төгрөг буюу -24.57% буурсан. Тайлант онд урт хугацаат өр төлбөрийн эргэн төлөлт төлбөрийн хуваарийн дагуу хийгдэж байгаа нь нөлөөлсөн байна. Нийт өр төлбөрийн 49.15% буюу 4,298,220,315 төгрөг нь урт хугацаат өр төлбөр, үлдсэн нь богино хугацаат өр төлбөрөөс бүрдэж байна.

Санхүүгийн харьцааны гол үзүүлэлтээс харахад тайлант хугацаанд компанийн төлбөрийн чадвар болон тогтвортой байдлыг харуулах гол харьцаа үзүүлэлтүүдийг авч үзвэл төлбөр түргэн гүйцэтгэх чадварын хувьд 0.30 байгаа нь хэвийн хэмжээнд байна.

Иймд дээр дурдсан санхүүгийн үзүүлэлтийн өсөлт, үр ашигтай байдал (түүнчлэн аудитын дүгнэлтээр тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн стандартыг баримталж, санхүүгийн зөрчилгүй ажилласныг баталгаажуулсан) зэргийг үндэслэн ТУЗ-ийн зүгээс санхүүгийн үйл ажиллагааг “Хангалттай” гэж дүгнэв.

Цаашид компанийн үр ашгийг нэмэгдүүлэх, хувьцаа эзэмшигч хөрөнгө оруулагчдын хөрөнгийн өгөөжийг тогтворжуулах чиглэлд анхааран, ТУЗ болон (аудитын байгууллага)-с өгсөн чиглэлийн дагуу шаардлагатай арга хэмжээг авч ажиллахыг Компанийн гүйцэтгэх удирдлагад зөвлөмж болгов.